

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 20/3

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүү, макро зохистой бодлогын арга хэмжээний талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдалд гарч буй гол өөрчлөлтүүд, Ковид-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

Инфляцын төсөөлөл 2020 онд өмнөх төсөөллөөс буурсан болохыг танилцуулав. Тодруулбал, КОВИД-19 вирусын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил саарч, эрэлтийн шалтгаантай инфляц бага түвшинд хадгалагдах, дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийг даган дотоодын шатахууны үнэ буурсан, мөн махны нийлүүлэлт тогтвортой байх хүлээлттэй байгаагаас нийлүүлэлтийн шинжтэй инфляц нэмэгдэхээргүй байна. Улмаар инфляцын түвшин 2020 онд Монголбанкны зорилтот түвшин (8%)-ээс бага, дунд хугацаанд зорилтот түвшин (6%)-ий орчимд тогтворжих төлөвтэй байна.

Бодит эдийн засгийн төлөв 2020 оны эхний 5 сарын салбарын үзүүлэлтүүдээс харахад сул хэвээр байна. 2020 онд эдийн засгийн өсөлтийн төсөөлөл -0.9 хувьд хүрж буурахад гадаад, дотоод эрэлтийн төлөв сулрах, түүхий эдийн үнэ буурах, КОВИД-19 вирусын эдийн засагт үзүүлэх нөлөө хүлээлтээс нэмэгдэн, үргэлжлэх хугацаа нь удааширч байгаа зэрэг нь голлон нөлөөлж байна. Цаашид гадаад эрэлт сэргэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх, зарим нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний экспорт сэргэх, ОТ-н зэсийн баяжмал дахь металлын агууламж сайжрах хүлээлттэй байгаа зэргээс 2021 онд эдийн засгийн өсөлтийг хэвийн түвшинд хүргэнэ гэж үзэж байна. Мөн хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд хүлээлтээс эерэг гарсан нь бусад эдийн засгийн макро үзүүлэлтүүдтэй зөрчилдөж байгаа болохыг онцлов.

МБГ-ын зүгээс төсвийн орлого их хэмжээгээр тасрах эрсдэлтэй байгааг танилцуулав. Тухайлбал, төсвийн нийт орлого энэ оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 834 тэрбум төгрөгөөр буурчээ. Мөн төсвийн шаардлагатай

санхүүжилт эхний 5 сард 1 их наяд 943 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд цаашид төсвийн алдагдал тэлэх хүлээлттэй байгаагаас алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн шаардлага нэмэгдэхээр байна.

Зээлийн өсөлт 2020 онд нам түвшинд хадгалагдахаар байна. Эдийн засгийн идэвхжил сул, тодорхой бус байдал нэмэгдсэнтэй зэрэгцэн банкны систем дахь эх үүсвэрийн долларжилт болон хугацаа хэтэрсэн зээлийн дүн өсч байгаа нь банкуудын иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн өсөлтийг хязгаарлаж байна. Түүнчлэн, бизнесийн зээлийг голлон бүрдүүлэгч том банкуудын хөрвөх чадвартай хөрөнгө буурч байгаа нь бизнесийн зээлийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх төлөвтэй.

Өмнөх бодлогын шийдвэрээс хойш КОВИД-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засгийн төлөв муудлаа. БНХАУ-д КОВИД-19-тэй холбоотойгоор үүссэн нөхцөл байдал сайжирч үйлдвэрлэл нь хэвийн түвшинд хүрсэн ч 6-р сарын дундуур БНХАУ-ын нийслэл Бээжин хотод вирус дахин дэгдсэн нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна. Мөн Европын орнуудын хорио цээрийн арга хэмжээ үргэлжилж, Өмнөд, хойд америкийн орнуудад тархалт эрчимжсэн зэргээс шалтгаалан БНХАУ-ын гадаад эрэлт буурч эдийн засгийн сэргэлт нь удаашрах эрсдэлтэй. Цаашид “КОВИД-19” вирусын тархалтыг улс орнууд ямар хугацаанд хяналтанд авахаас гадаад эрэлтийн төлөв хамаарахаар байна.

Сүүлийн саруудад экспорт талаас дэлхийн зах зээл дээрх алт, зэс, төмрийн хүдрийн үнэ нэмэгдсэн, импорт талаас газрын тосны үнэ харьцангуй бага түвшинд хадгалагдсан нь 2020 оны худалдааны нөхцөлийг өмнөх төсөөллөөс сайжруулахад голчлон нөлөөлөв.

Төлбөрийн тэнцэл 2020 онд муудах хандлагатай байна. Төлбөрийн тэнцэл 2020 оны эхний 4 сард 665 сая ам.доллар буюу ДНБ-ий 4.9 хувьтай тэнцэх алдагдалтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 988 сая ам.доллараар муудсан үзүүлэлт болов. Үүнд КОВИД-19-ийн нөлөөгөөр экспортын орлого огцом татарч, урсгал тэнцлийн алдагдал 442 сая ам.доллараар ихэссэний зэрэгцээ ГШХО, багцын хөрөнгө оруулалт, худалдааны зээлийн цэвэр урсгал буурснаар санхүүгийн дансны ашиг 291 сая ам.доллараар багассан нь голлон нөлөөлөв. Гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа нь цаашид төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх эрсдлийг нэмэгдүүлж байна.

Танилцуулгын төгсгөлд долларжилтын түвшин өндөр байх нь мөнгөний бодлого, түүний шилжих механизмын нөлөөг сулруулж, тогтворгүй, өндөр инфляц, ханшийн хэлбэлзлийг үүсгэх, мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд

хүндрэл учруулах, хүүний зөрүүг нэмэгдүүлэх, санхүүгийн системийг хямралд өртөмтгий, эмзэг болгох зэрэг сөрөг нөлөөтэй байдаг болохыг дурдав. Улмаар банкуудын эх үүсвэрийн долларжилтыг хязгаарлах, гадаад валютын харилцах, хадгаламжийн хүүг бууруулах чиглэлд “зах зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ)-нээс харьцангуй өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын хувь хэмжээнд үндэслэн Монголбанкнаас банкуудад олгох төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн урамшуулалд хорогдуулга хийх” бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзэн 2 хувилбар тооцооллыг танилцуулав.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 9 хувьд хэвээр хадгалах, Макро зохистой бодлогын хүрээнд Монголбанкнаас зарлагдсан ЖДХ-нээс нэгээс дээш нэгж хувиар өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын нийлбэрийг нийт гадаад валютын харилцах, хадгаламжийн дүнд харьцуулсан хувийг банк бүрээр тооцож, тэр хувиар Монголбанкнаас банкинд олгох төгрөгийн ЗБН-ийн урамшууллыг хорогдуулах санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

МБХ-ны зарим гишүүний хувьд эдийн засгийн өсөлтийг дэмжих, банкны салбарт өрсөлдөөнийг бий болгох зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж 8.5 хувьд хүргэх саналыг гаргав.

Бусад гишүүдийн хувьд бодлогын хүүг 2020 оны 3 болон 4 дүгээр сарын хурлаар дарааллан 1 нэгж хувиар буулгаж 9 хувьд хүргэсэн нь тодорхой хэмжээнд эх үүсвэрийн хүүг бууруулаад байгаа хэдий ч эдийн засагт нөлөө нь бүрэн гарч амжаагүй байгаа гэж үзсэн. Тодруулбал, өмнөх бодлогын үр нөлөө бүрэн гараагүй, КОВИД-19 вирусээс үүдэн тодорхой бус байдал их байгаа энэ үед дараагийн бодлогын санал хүртэл бодлогын хүүг хэвээр нь хадгалж, цаашид нөхцөл байдал яаж өөрчлөгдөхийг харгалзаж үзэх нь зүйтэй гэж үзсэн. Мөн нөхцөл байдал муудсан тохиолдолд бодлогын хүүгээр эдийн засгийг дэмжих орон зайгаа хадгалах зорилгоор бодлогын хүүг хэвээр хадгалах нь чухал болохыг онцолсон.

Гишүүд макро зохистой бодлогын саналыг дэмжиж байгаагаа илэрхийлэв. Энэхүү арга хэмжээ нь өмнөх мөнгөний бодлогын хурлаар гаргасан гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмсэн арга хэмжээтэй нягт уялдан эх үүсвэрийн долларжилт болон гадаад валютын харилцах, хадгаламжийн хүүг бууруулна гэж үзсэн.

Ийнхүү, Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 дугаар сарын 26-ны ээлжит хуралдаанд нийт 6 гишүүн оролцож бодлогын хүүг 9 хувьд хэвээр нь хадгалах саналыг 5 гишүүд дэмжсэн бол макро зохистой бодлогын саналыг МБХ-ны гишүүд 100 хувь дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар

- 1) Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд бодлогын хүүг хэвээр хадгалах,
- 2) Банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг тус тус гаргалаа.